

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:
 - 2.1. Бодлого, төлөвлөлтийн газар (судалгаа, шинжилгээний хэлтэстэй);
 - 2.2. Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (цахим засаглалын хэлтэс, нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтэстэй);
 - 2.3. Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (сансрын холбооны хэлтэс, шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтэстэй);
 - 2.4. Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
 - 2.5. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);
 - 2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.
3. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны орон тооны дээд хязгаарыг 87 байхаар тогтоосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.НЯМДОРЖ